



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2019 ОНЫ ЗАРЦУУЛАЛТ

НАГ/2020/-05-НА



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу хуваарилсан хэдий ч хөрөнгийн зарцуулалтад зарим холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй, хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Орхон аймаг
2020 он

Агуулга

Аудитыг гүйцэтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	1
Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл.	2
Ц.Нармандах	Үндсэн мэдээлэл	3
Аудитын менежер:	БҮЛЭГ 1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу хуваарилсан хэдий ч аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу хуваарилсан эсэх нь тодорхойгүй байна.	4
Б.Эрдэнэ	1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.	4
Ахлах аудитор:	1.1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн байна.	4
Б.Буян-Ундрах	1.1.2 ОНХНС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн дагуу бүрдүүлсэн байна.	5
Аудитор:	1.1.3 ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.	5
Д.Цогбадрах	1.2 Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу бүрдүүлж хуваарилсан байна.	5
2020 оны 11 дүгээр сар	1.2.1 Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөсөн байна.	5
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70357955, 70350757 дугаарын утас, 70359826 дугаарын факсаар харилцана уу.	1.2.2 ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн байна.	5
Уг тайланг ҮАГ-ын веб сайтаас үзнэ үү.	1.2.3 Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу хуваарилсан эсэх нь тодорхойгүй байна.	6
www.audit.mn	БҮЛЭГ.2 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад зарим холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна.	7
Хаяг: Орхон аймаг дахь төрийн аудитын газар	2.1 Иргэдийн саналаар дэмжигдээгүй, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй ажлыг төлөвлөж, ИТХ-аар баталсан байна.	7
Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон	2.1.1 Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, ТАХ-г төлөвлөхдөө холбогдох журмыг баримтлаагүй байна.	7
	2.1.2 Аймгийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г журмын дагуу төлөвлөөгүй байна.	9
	2.2 ОНХС-ийн хөрөнгөөр ТАХ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн зарим заалтыг зөрчсөн байна.	10
	2.2.1 Сангийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн зарим заалтуудыг зөрчин зохион байгуулсан байна.	10

2.2.2 Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.	11
2.2.3 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгийг ашиглагч байгууллагын өмчид бүртгэсэн байна.	12
БҮЛЭГ.3 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.	13
3.1 Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба ОНХС-ийн 2019 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.	13
3.1.1 2019 онд ОНХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	13
3.1.2 СХАА-аас 2 суманд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилт тайлант онд бүрэн хангагдсан байна.	13
3.2 ОНХС-ийн үйл ажиллагааны явцын мэдээг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	14
3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний тайлан мэдээг дээд шатны байгууллагад хүргүүлэхдээ хууль, журамд заасан хугацааг баримталж ажилласан хэдий ч ХОХБТХ нь цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулаагүй байна.	14
3.2.2 Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.	15
3.3.3 ОНХС-ын үйл ажиллагаа 53 хувьтай үнэлэгдсэн байна.	16
Дүгнэлт.....	17
Зөвлөмж.....	18
Холбогдох байгууллагын санал.....	19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
БИНХ	Багийн Иргэдийн нийтийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид
МУ	Монгол улс
НББ	Нягтлан бодох бүртгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНО	Олон нийтийн оролцоотой
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
СЗДТГ	Сумын Засаг даргын Тамгын газар
СОНХС	Сумын орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТТХ	Төсвийн тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ХА	Харьцуулалтын арга
ХААГ	Хөдөө аж ахуйн газар
ХБББ	Хөгжлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШГ	Шууд гэрээ
ТББ	Тендерийн баримт бичиг

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны аудитын төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

ОНХС-ийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг ҮАГ-т хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийгдлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг журмын дагуу төлөвлөж, зарцуулсан эсэх.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн болон 2 сумын ОНХС-ийн хөрөнгийн 2019 оны үйл ажиллагаа, аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, баг, хорооны ИНХ-ыг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн аудит. Тулгуур зарчим MNS6817:2020, нийцлийн аудитын зарчим MNS6817-6:2020, МУЕА-ын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан, аймаг, сумдын ЗДТГ, СТСХ болон холбогдох хэлтсийн албан тушаалтантай ярилцах, санал асуулга авах, дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөөг тайлантай тулгах, баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” ;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Аудит хийж гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, аудитын менежер Б. Эрдэнэ аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, ахлах аудитор Б.Буян-Ундрах, аудитор Д.Цогбадрах нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу нэгдсэн удирдамжаар хийж гүйцэтгэв.

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:

Аудитын талбарын ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн, тайланг 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн дотор үе шатны хяналтаар оруулж, Тэргүүлэх аудитораар баталгаажуулж, 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн дотор ҮАГ-т хүргүүлээ.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх:

Бүлэг 1

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу хуваарилсан хэдий ч аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу хуваарилсан эсэх нь тодорхойгүй байна.

1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.

1.1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэхээр заасан байна.

- Импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь
- Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь
- Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг
- Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь

Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас 2019 онд Орхон аймгийн ОНХС-д 4,972.5 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хуваарилахаар төлөвлөсөн байна. Орлогын шилжүүлгээс хуваарилах дүнг нэр төрлөөр авч үзвэл:

Хүснэгт №1

/ Сая төг/

Дотоодын НӨАТ	Газрын тосны НАТ	АМНАТ	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	ОУ-ын төсөл хөтөлбөрөөс сумдын ОНХС- д олгох урамшуулал	ОУ-ын төсөл хөтөлбөрөөс сумдын ОНХС- д олгох дэмжлэг
1,418.9	556.1	2,294.9	0.0	176.0	526.8

Үүнээс аймгийн ОНХС-д 61.9 хувь буюу 3,079.3 сая төгрөг, сумдын ОНХС-д 38.1 хувь буюу 1,893.2 сая төгрөг хуваарилахаар төлөвлөсөн байна.

1.1.2 ОНХНС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн дагуу бүрдүүлсэн байна.

2019 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 4,972.5 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээг 301.1 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

1.1.3 ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

Монгол улсын 2019 оны Төсвийн тухай хуульд заасан ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 4,972.5 сая төгрөгийг бүрэн олгосон байна.

1.2 Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу бүрдүүлж хуваарилсан байна.

1.2.1 Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулиар аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэр нь ОНХНС-аас олгох шилжүүлэг, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгох гадаад дотоодын дэмжлэг тусламж, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого зэргээс бүрдэхээр заасан байдаг.

Аймгийн ОНХС-ийн 2019 оны эх үүсвэрийг 5,020.78 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүний 4,972.49 сая төгрөг нь нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг, 33.09 сая төгрөг нь өмнөх оны үлдэгдлээс, 15.20 сая төгрөг нь баяр наадмын орлогоос бий болгосон нэмэгдэл эх үүсвэрээс бүрдэхээр төлөвлөсөн байна.

1.2.2 ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрт 5,020.78 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 5,020.78 сая төгрөг төвлөрсөн байна.

ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №2

/ Сая төг /

№	Эх үүсвэр	Төлөвлөг өө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл ийн хувь
1	ОНХНС-аас олгох	4,972.49	4,972.49	0	100%
2	Өмнөх оны зарцуулаагүй үлдэгдэл	33.09	33.09	0	100%
3	Бусад орлого	15.20	15.2	0	100%
Нийт дүн		5,020.78	5,020.78	0	100%

1.2.3 Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу хуваарилсан эсэх нь тодорхойгүй байна.

Төсвийн тухай хуулийн 56.4¹-т заасны дагуу Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д “орон нутгийн хөгжлийн индекс–харгалзах хувийн жин 25 хувь”, 3.2.2-д “хүн амын тоо–харгалзах хувийн жин 25 хувь”, 3.2.3-д “Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ–харгалзах хувийн жин 25 хувь”, 3.2.4-д “Орон нутгийн татварын идэвх санаачилга–харгалзах хувийн жин 25 хувь” гэсэн хүчин зүйлсээр тооцож хуваарилалт хийгдэх ёстой байдаг.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 12/04 дугаар тогтоолоор Орхон аймгийн 2019 оны орон нутгийн хөгжлийн сангаас Баян-Өндөр сумд 988.9 сая төгрөг, Жаргалант сумд 904.2 сая төгрөгийг хуваарилсан байна. Сумдын хөгжлийн индекс, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн алслалт, орон нутгийн татварын идэвх санаачилга зэргийг харгалзан үзэж сумдад олгох орлогын шилжүүлгийг хуваарилсан талаарх тооцоолол аймаг дээр хийгдээгүй байна. Сангийн яаманд тооцоолол хийгдсэн гэх боловч яг аргачлалын дагуу хийгдсэн эсэх талаар нотлох баримт байхгүй байна.

¹ Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлал, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандарт, тэдгээрийн орцын болон төсвийн нормативыг Засгийн газар тогтооно

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж зааврыг баримталсан эсэх:

Бүлэг 2

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад зарим холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна.

2.1 Иргэдийн саналаар дэмжигдээгүй, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй ажлыг төлөвлөж, ИТХ-аар баталсан байна.

2.1.1 Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, ТАХ-г төлөвлөхдөө холбогдох журмыг баримтлаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 12/04 дугаар тогтоолоор 2019 онд 2 суманд СОНХС-ийн хөрөнгөөр нийт 1893.2 сая төгрөгийн ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан байна. Эдгээр ТАХ-ыг иргэдээс санал авч хэлэлцүүлсэн эсэхийг үзэхэд сумдад иргэдээс батлагдсан маягтын дагуу саналыг авч, багийн ИНХ-аар хэлэлцүүлэн ач холбогдол, санал авсан тоогоор эрэмбэлэн, тогтоолоор баталсан байна. Төсвийн тухай хуулийн 63.1², 63.2³ заалт болон Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.1⁴, 3.1.2⁵-т заасныг зөрчин иргэдийн саналаар гарч эрэмбэлэгдээгүй дараах ТАХ хэрэгжүүлсэн байна.

Баян-Өндөр сумын хувьд:

- Антибиотекийн үлдэгдэл тодорхойлох оношлуур /20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Нийтийн эзэмшлийн зам талбайн ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис /15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Нөөцийн өвс, тэжээл бэлтгэх /50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Түлээний мод бэлтгэх /12.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Сав, баглаа боодол /15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Холбооны уулзвараас 1-16 дугаар байрны төгсгөл хүртэлх явган хүний зам 27.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Уртын гол баг автомашины болон явган хүний гүүрэн гарц хийх ажил /11.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Рашаант баг 19, 26 гудамжинд явган хүний гарц /8.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Рашаант баг 33, 34 гудамж жишиг болгон тохижуулах /10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Цагаанчулуут баг жишиг гудамжны тохижилт /28.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/

² Баг хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулах

³ Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны ИНХ-д гарсан саналыг ИНХ хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно

⁴ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

⁵ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

- Цагаанчулуут баг жишиг гудамжны /25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Уртын гол баг гэрэлтүүлэг хийх /16.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Говил баг. 160 ква дэд өртөө байгуулах /40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Говил баг. Отгонтэнгэр буудлаар тойрсон гэрэлтүүлэг /35.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Их залуу, Яргуйт багийн ахмадын байрыг дулааны шугамд холбох /29.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Оюут баг. 8-р сургуулийн гадна талбайн тохижилт /15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Ирээдүйн одод сургуулийн мэдээлэл зүйн кабинетийн тохижилт /15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Баянцагаан соёлын төвд эд хогшил /16.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Хэмнэл соёлын төвд эд хогшил /9.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Эгшиглэн соёлын төвд эд хогшил /5.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Спортын төхөөрөмж, хэрэгсэл /15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмж /15.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- БОЭТ, 11-р цэцэрлэг, багийн ахмадуудын байранд тоног төхөөрөмж /8.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Малчин хороололд бэлчээрийн худаг шинээр байгуулах /15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Булагтын "В" хэсгийн худгийг орон нутгийн мэдэлд авах /6.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Мэдээллийн хэрэгслийн тоног төхөөрөмж /15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/

Жаргалант сумын хувьд:

- Эрүүл мэндийн төвийн дээвэр засварлах /14.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Хөшөөтөд малын тарилга туулгалтын хашаа барих /8.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Булаг, шувуутын дунд малын тарилга туулгалтын хашаа барих /8.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Улаантолгой багийн байрны дотор засвар хэсэгчлэн засах /8.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Төмөр замын худгийн гадна талыг хашаажуулах /8.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Улаантолгой багийн гадна талын хашаа /6.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Жаргалантын хөлд байрлах худгийн байшин барих /7.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Зорилтод бүлгийн иргэдэд гэр худалдан авах /28.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/

Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ нь сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан ч тухайн оны сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй байна. Үүнд:

- Түлээний мод бэлтгэх /12.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Сав, баглаа боодол /15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/

- Рашаант баг 33, 34 гудамж жишиг болгон тохижуулах /10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Булаг баг жишиг гудамжны тохижилт /28.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Цагаанчулуут баг жишиг гудамжны тохижилт /28.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Цагаанчулуут баг жишиг гудамжны тохижилтын ажил /25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Оюут баг. 8-р сургуулийн гадна талбайн тохижилт /15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/
- Мэдээллийн хэрэгслийн тоног төхөөрөмж /15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/

Жаргалант сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дараах ТАХ байна. Үүнд:

- Улаантолгой багийн гудамж хоорондын сайжруулсан зам хэсэгчлэн тавих

2.1.2 Аймгийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г журмын дагуу төлөвлөөгүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд нийт 2,711.3 сая төгрөгийн 18 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. /2018 оноос шилжсэн 2 ажил/

Дээрх ажлууд нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2016-2020/, аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдсан хэдий боловч аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө урьдчилсан жагсаалт боловсруулж, иргэдээр хэлэлцүүлэн эрэмбэлээгүй байна. Мөн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ны нэгдсэн жагсаалтыг 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор ЗД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй, ТАХ-г аймгийн ИТХ батлагдсан маягтын дагуу батлаагүй байна.

Дээрх үйл ажиллагаа нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7.2⁶, 7.5⁷, 7.6⁸, 7.7⁹, 7.7¹⁰ дахь заалтуудтай нийцээгүй тул зөвлөмж хүргүүлэв.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэх төсөл арга хэмжээний санал, асуулгыг 2015 онд “Эдийн засаг, санхүүгийн зөвлөгөө өгөх хөгжил төв” ТББ-тай, 2016 онд “Олон нийтийн оролцоотой хөгжлийн төв” ТББ-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн байна. Тухайн ТББ-уудын авсан санал асуулгын 1-д хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох ажил 16649 саналаар

⁶ Ажлын хэсэг аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзэж боловсруулна.

⁷ Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг 7 дугаар сард багтаан 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

⁸ Аймаг, нийслэлийн Засаг дарга иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хамгийн олон санал авсан, ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна.

⁹ Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

¹⁰ Аймаг, нийслэлийн ИТХ нь аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн саналыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр хэлэлцэн энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу батална.

эрэмбэлэгдсэн байна. Санал асуулгыг үндэслэн “МОН2301 төслөөр баригдсан цэвэр бохир усны шугамын 1-р эх үүсвэр (2-р хэсэг)” ТАХ-г эхлүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 11 сарын 30-ны өдрийн 12/04 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ын хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх ТАХ-г батлахдаа 1,272.2 сая төгрөгийн шинээр эхлэх хөрөнгө оруулалтын ажлыг баталсан байна.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр ТАХ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн зарим заалтыг зөрчсөн байна.

2.2.1 Сангийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн зарим заалтуудыг зөрчин зохион байгуулсан байна.

Улсын төсвөөс 4,719.5 сая төгрөг батлагдсанаас аймагт 2,826.4 сая төгрөг, Баян-Өндөр суманд 988.9 сая төгрөг, Жаргалант суманд 904.2 сая төгрөгийг хуваарилсан байна.

Аймгийн хувьд өмнөх онуудаас шилжсэн “МОН2301 төслөөр баригдсан цэвэр бохир усны шугамын 2-р эх үүсвэр” ТАХ-нд 1,405.9 сая төгрөг, Баянцагаан багийн нутаг дэвсгэрийн 290 га газарт шинээр шинэ орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар боловсруулан гүйцэтгүүлэхэд 33.0 сая төгрөг хуваарилсан байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний сонгон шалгаруулалтын журмын хэрэгжилтийг үзэхэд 4 ТАХ буюу 25 хувийг НТШ, 12 ТАХ буюу 75 хувийг ХА-аар байгуулсан байна.

2019 онд шинээр “Их залуу баг УДДТөв барих” ТАХ-нд 362.0 сая төгрөг, гэр хорооллын багуудад сайжруулсан шороон зам хийхэд 870.3 сая төгрөг, Говил, яргуйт багийн камержуулалтад 79.9 сая төгрөг, Үндэсний баяр наадмын зардалд 115.2 сая төгрөгийг хуваарилсан байна.

Засгийн газрын 271 дүгээр тогтоолоор Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 сая төгрөг байхаар баталсан байтал Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс баяр наадмын зардалд 100.0 сая төгрөг зарцуулсан байна.

2019 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Баян-Өндөр суманд 993.5 сая төгрөгийн төсөвт өртгөөр 49 ТАХ-г төлөвлөн, хэрэгжүүлсэн байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний сонгон шалгаруулалтын журмын хэрэгжилтийг үзэхэд нийт ХАА-ны 36 ТАХ буюу 73.5 хувийг ХА, 13 ТАХ буюу 26.5 хувийг ШГ байгуулсан байна.

Баян-Өндөр сумын 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны явцад дараах нийтлэг зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- *Баян-Өндөр сум 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө зарласан нийт 31 ТАХ-г харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй. Энэ нь нэмэлт өөрчлөлт ороогүй байсан ТБОНӨХБАҮХАТ хуулийн 33.2.1¹¹-т” заасныг зөрчсөн байна.*
- *Шууд гэрээ байгуулахдаа хуулийн 14-16-р зүйлийн шаардлагыг хангасан эсэх талаар баримтуудыг бүрэн бүрдүүлж аваагүй байна. Мөн 14-16-р зүйлийн шаардлагыг хангаагүй компаниудтай гэрээ байгуулсан нь хуулийн 34.2¹² дахь заалттай нийцэхгүй*

¹¹ техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэл хүргүүлнэ

¹² Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ

байна. Жишээ нь: Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгч компани нь 36.0 сая төгрөгийн өртэй байтал шууд гэрээ байгуулсан.

- Хуулийн 34.3¹³ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.
- ТББ-т гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг хавсаргаагүй байгаа нь хуулийн 34.2¹⁴ дахь заалттай нийцэхгүй байна.
- Согоот баг 6-12-р байрны хажууд хүүхдийн тоглоомын талбайн ажилд тендер хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулаагүй. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 28.2¹⁵-т заасныг зөрчсөн байна.
- Сангийн сайдын 2012 оны 212 дугаар тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, урамшууллыг зохицуулах журам”-д заасны дагуу тендерийн үнэлгээний хороог 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр сумын Засаг даргын захирамжаар томилсон байна. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд аймгийн ИТХ-ын төлөөлөгч орсон.

Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 26 ТАХ-ний сонгон шалгаруулалтын журмын хэрэгжилтийг үзэхэд 50 хувийг ХА, 50 хувийг ШГ байгуулсан байна.

Жаргалант сумын 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны явцад дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- “Бошголсон” ХХК, “Хас үндэс” ХХК зэрэг татварын өртэй компаниудтай гэрээ байгуулсан.
- Орон сууцны узел засварын ажлын худалдан авах ажиллагааг зарлахдаа 5 хоногоор зарлаагүй нь хуулийн 33.3¹⁶ дахь заалттай нийцээгүй байна.
- Улаантолгой баг үерийн хамгаалалтын шороон овоолгын ажлын урилгыг цахилгаан, гэрэлтүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН-д хүргүүлсэн. Тухайн ажил дээр 2.3.2 дахь заалтыг шаардах ёстой байтал 2.1.2, 2.2.2 дахь заалтуудыг шаардсан.

Дээрх зөрчлийг гаргасан сумдын Засаг дарга нарт хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2.2 Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 58.4 дүгээр зүйлд сум өөрийн төсвөөр хэрэгжүүлэх ТАХ-ний чиг үүргийг тодорхойлсон байна.

Гэтэл дараах сумдад Төсвийн тухай хуульд заасан чиг үүрэгт хамаарахгүй болон урсгал зардлын шинжтэй ТАХ-г хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Баян-Өндөр сумын Баянцагаан соёлын төвд эд хогшил худалдан авахад 16.7 сая төгрөг,
- Баян-Өндөр сумын Хэмнэл соёлын төвд эд хогшил худалдан авахад 9.7 сая төгрөг,
- Баян-Өндөр сумын Эгшиглэн соёлын төвд эд хогшил худалдан авахад 5.0 сая төгрөг,
- Баян-Өндөр сумын ЗДТГ-т Мэдээллийн хэрэгслийн тоног төхөөрөмж худалдан авахад 15.0 сая төгрөг,
- Баян-Өндөр сумын ЗДТГ-т спортын тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авахад 15.0 сая төгрөг,

хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

¹³ Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

¹⁴ 49.2 Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ: 49.2.8.гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр, гэрээ;

¹⁵ Тендерийн үнэлгээг тендер хүчинтэй байх хугацаанд багтааж аль болох богино хугацаанд хийнэ.

¹⁶ Энэ хуулийн 33.2.1-д заасан үнийн санал ирүүлэх хугацааг урилга зарласан өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтооно.

- Баян-Өндөр сумын Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмж худалдан авахад 15.1 сая төгрөг,
- Баян-Өндөр сумын Ирээдүйн одод сургуулийн мэдээлэл зүйн кабинетын тохижилтын тохижилтод 15.0 сая төгрөг,
- БОЭТ, 11-р цэцэрлэг, багийн ахмадын байранд тоног төхөөрөмж худалдан авахад 8.0 сая төгрөг,
- Жаргалант сумын цэцэрлэгт ширээ, сандал худалдан авахад 8.8 сая төгрөг,
- Жаргалант суманд Улс, аймгийн зэрэглэлтэй спортын бага наадам, уралдаан тэмцээнийг зохион байгуулах зардалд 10.7 сая төгрөг ,
- Орхон аймгийн хэмжээнд 3000 залуучуудын цугларалтад Жаргалант сумаас оролцох 100 залууст хувцас, цүнх худалдан авч өгөхөд 12.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 60.3-т заасныг зөрчиж байна. Иймд дээрх зөрчилд холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2.3 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгийг ашиглагч байгууллагын өмчид бүртгэсэн байна.

2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр нийлүүлсэн нийт 349.2 сая төгрөгийн бараа, тоног төхөөрөмж, 3,568.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг Орон нутгийн өмчийн газраас хөрөнгөнд бүртгэсэн тухай тодруулж, мөн байгууллагын хөрөнгийн бүртгэлийг хянан үзэхэд 349.2 сая төгрөгийн бараа, тоног төхөөрөмж, 2,162.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг бүртгэжээ. МОН-2301 төслөөр баригдсан цэвэр усны шугамын 2-р эх үүсвэр (1-р хэсэг) ажилд Улсын комисс ажиллаагүй он дамжсан тул Орон нутгийн өмчийн газрын дуусаагүй барилга дансанд бүртгэсэн байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх:

Бүлэг 3 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

3.1 Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба ОНХС-ийн 2019 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

3.1.1 2019 онд ОНХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.4-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина” гэж заасан байна.

Аймаг, сумдын ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилтэд ИТХ-н дэргэдэх Хяналтын хороо болон иргэд иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1.2 СХАА-аас 2 суманд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилт тайлант онд бүрэн хангагдсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-д гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг Төсвийн тухай хуулийн 69.1¹⁷-д заасан байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан байна.

2019 оны аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019 оны хяналт, шалгалтын төлөвлөгөө, аймгийн засаг даргын баталсан 21/20, 26/20 тоот удирдамжуудын дагуу Баян-Өндөр, Жаргалант сумдын 2019 оны ОНХС-ийн үйл ажиллагаанд аудит хийсэн байна.

Аудитаар Баян-Өндөр суманд Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-д заасан заалт, худалдан авах гэрээний Тав. “Гэрээний хариуцлага” заалтыг зөрчсөн зөрчлүүдийг арилгуулах, үүрэг бүхий 3 албан шаардлага, эрсдэлээс урьдчилан сэргийлэх 5 зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

¹⁷ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

Мөн аудитаар Жаргалант суманд дүгнэж иргэдийн олонхын саналаар дэмжигдээгүй буюу санал аваагүй нийт 13 бараа, ажил үйлчилгээний 222.7 сая төгрөгийн санхүүжилтийг ИТХ-аар батлуулсан, 2018-2019 оны нийт 8 арга хэмжээний 106.2 сая төгрөгийн дуусаагүй ажлын үлдэгдэл, Улаантолгой багт үерийн далангийн хамгаалалтын шороон овоолгын ажил 50.1 сая төгрөгийн гэрээ хийгдэж ажил хийсэн боловч чанаргүй Улсын комисс хүлээж аваагүй, мөн Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д заасан заалт болон ОНХС-ийн журмын 4.2-д заасан заалтыг хангалтгүй хэрэгжүүлж нийт ОНХС-ийн суурь зардлаас 148.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлдсэн, 78.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг иргэдэд үнэ төлбөргүй олгосон, сумын иргэдэд болон ажилчдад зориулан уралдаан тэмцээний зардалд 6.6 сая төгрөг зарцуулсан зэрэг зөрчлүүдийг арилгуулах, үүрэг бүхий 3 албан шаардлага, эрсдэлээс урьдчилан сэргийлэх 6 зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

3.2 ОНХС-ийн үйл ажиллагааны явцын мэдээг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

3.2.1 ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний тайлан мэдээг дээд шатны байгууллагад хүргүүлэхдээ хууль, журамд заасан хугацааг баримталж ажилласан хэдий ч ХОХБТХ нь цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.3-т “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна” гэж заасан байна.

2019 онд ОНХС-ийн хэрэгжилтэд дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийг боловсруулж шийдвэрлүүлэх ажил хийгдээгүй байна.

Дээрх зөрчилд холбогдох албан тушаалтанд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мөн ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.2¹⁸-т заасан тайлан мэдээг хүргүүлсэн эсэхийг үзэхэд аймгийн сумдын ЗДТГ-ын дарга нь ХОХБТХ-т хэрэгжилтийн жилийн тайланг хүргүүлсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.1-д “... сумын санхүүгийн алба нь ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ журмын 10 дугаар хавсралтад заасны дагуу аймгийн СТСХ-т Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах хугацаанд тайлагнана” гэж заасан байна.

¹⁸ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9- д заасан мэдээллийг багтаана.

Дээрх журам заасны дагуу 2 сум 2019 оны ОНХС-ийн жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хавсралт маягтаар аймгийн СТСХ-д ирүүлж, мэдээллийн санд мэдээлсэн байна.

3.2.2 Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

ОНХС-ийн 2018 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг үзэхэд дараах байдалтай байна.

Өмнөх оны акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн байдал /сая төгрөг/

Үзүүлэлт	Тогтоосон		Хугацаандаа хэрэгжсэн		Хугацаандаа хэрэгжээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	9	0	9	0	0	0	100%
Албан шаардлага	5	214.0	5	214.0	0	0	100%
Дүн	14	214.0	14	214.0	0	0	100%

“ОНХС-ын 2018 оны хөрөнгийн зарцуулалт” нийцлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.3.3 ОНХС-ын үйл ажиллагаа 53 хувьтай үнэлэгдсэн байна.

“Тогтвортой амьжиргаа-3” ТХН 2019 онд ОНХС-ын жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 2019 оны 06 сард хөндлөнгийн аудитын байгууллагуудаар хийлгэсэн байна. Тухайн үнэлгээгээр Баян-Өндөр сум 55 хувиар, Жаргалант сум 50 хувиар үнэлэгдсэн байна.

Гүйцэтгэлийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

Сумын нэр	Олон нийтийн оролцоо	Төлөвлөлт	Ил тод байдал	Гүйцэтгэл	ХШҮ	Өмчийн удирдлага	Сумын Үнэлгээ
Баян-Өндөр	54%	79%	33%	24%	75%	79%	55%
Жаргалант	70%	54%	22%	47%	75%	41%	50%
Сумдын дундаж	62%	66%	28%	35%	75%	60%	53%

Аудитын явцад ОНХС-ийн үйл ажиллагаа орон нутагт хэрхэн хэрэгждэг, иргэдэд сурталчилдаг эсэх, иргэн таны оролцоо хэрхэн хангагддаг болон бодит үр дүн бүхий төсөл арга хэмжээ байгаа эсэх талаар 1329 иргэнээс санал асуулга авсан.

Санал асуулгын нэгтгэлийн хүснэгтээр харуулбал:

№	Санал асуулга	Үзүүлэлт	Дүн	Эзлэх хувь
0	Хүн амын тоо /тухайн орон нутгийн/	Нийт хүн амын тоо	104412	
		Судалгаанд оролцсон хүний тоо	1329	1.3%
1	Нас /дундаж/	-	42	
2	Орон нутгийн хөгжлийн сангийн талаар хэр мэдээлэлтэй вэ?	Хангалттай	697	52.4%
		Хангалтгүй	632	47.6%
3	Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх мэдээллийг хаанаас авсан бэ?	Засаг дарга, хороодын хэсгийн ахлагч	745	56.1%
		Орон нутгийн мэдээллийн самбар, радио, телевиз	387	29.1%
		Иргэний танхимын ажилтан	59	4.4%
		Нутгийн иргэдээс	138	10.4%
4	Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль тогтоомж, журам зааврыг судалж үзсэн уу?	Тийм	494	37.2%
		Үгүй	835	62.8%
5	Таны баг, хорооны Засаг дарга 2019 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хамгийн түрүүнд хийх шаардлагатай ажлуудын саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулсан уу?	Тийм	749	56.4%
		Үгүй	230	17.3%
		Сайн мэдэхгүй байна	350	26.3%
6	Та энэ үйл ажиллагаанд оролцож саналаа өгсөн үү?	Тийм	660	49.7%
		Үгүй	669	50.3%
7	Засаг дарга ийнхүү авсан саналыг эрэмбэлж, хамгийн их санал авсан ажлуудыг иргэдэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн үү?	Тийм	657	49.4%
		Үгүй	210	15.8%
		Сайн мэдэхгүй байна	462	34.8%
8	Та нээлттэй хэлэлцүүлэгт оролцсон уу?	Тийм	544	40.9%
		Үгүй	785	59.1%
9	Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодитой хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаг уу?	Тийм	659	49.6%
		Үгүй	670	50.4%
10	Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад хэр сэтгэл хангалуун байдаг вэ?	Хангалттай сайн	690	52.0%
		Хангалтгүй	293	22.0%
		Мэдэхгүй байна.	346	26.0%

Санал асуулгад аймгийн нийт хүн амын 1.3 хувийг хамрууллаа.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.
- Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу бүрдүүлж хуваарилсан байна.
- Иргэдийн саналаар дэмжигдээгүй, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй ажлыг төлөвлөж, ИТХ-аар баталсан байна.
- Сангийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн зарим заалтуудыг зөрчин зохион байгуулсан байна.
- Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.
- Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгийг ашиглагч байгууллагын өмчид бүртгэсэн байна.
- 2019 онд ОНХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- СХАА-аас 2 суманд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилт тайлант онд бүрэн хангагдсан байна.
- ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний тайлан мэдээг дээд шатны байгууллагад хүргүүлэхдээ хууль, журамд заасан хугацааг баримталж ажилласан байна.
- Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА С.БАТЖАРГАЛ ТАНАА

1. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7.2¹⁹, 7.5²⁰, 7.6²¹, 7.7²², 7.7²³ дахь заалтуудыг мөрдөж ажиллах.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭСТ

1. Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.3 дахь заалтыг хэрэгжүүлж, ОНХС-ын хэрэгжилтийн тайланд дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулж байх.

БАЯН-ӨНДӨР, ЖАРГАЛАНТ СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

1. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх.
2. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14-16-р зүйлийн шаардлагыг хангаагүй компаниудтай гэрээ байгуулахгүй байх.
3. Тендерийн баримт бичигт гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг хавсаргаж, тендерийн үнэлгээг тендер хүчинтэй байх хугацаанд багтааж аль болох богино хугацаанд хийж байх.
4. Тендерийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг үнэн зөв боловсруулах.
5. ОНХС-ын хөрөнгөөс Төсвийн тухай хуульд заасан чиг үүрэгт хамаарахгүй болон урсгал зардлын шинжтэй ТАХ-г санхүүжүүлэхгүй байх.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ
ТАЙЛАН БИЧСЭН:
АХЛАХ АУДИТОР: Б.БУЯН-УНДРАХ
АУДИТОР: ЦОГБАДРАХ
6117143690
9042888

¹⁹ Ажлын хэсэг аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзэж боловсруулна.

²⁰ Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг 7 дугаар сард багтаан 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

²¹ Аймаг, нийслэлийн Засаг дарга иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хамгийн олон санал авсан, ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна.

²² Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

²³ Аймаг, нийслэлийн ИТХ нь аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн саналыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр хэлэлцэн энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу батална.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Тайланд тусгах саналгүй тул албан бичгүүдийг хавсаргав.



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг,
Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон,
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
И-мэйл: info@erdenet.mn

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2020.12.08 № 07/2441
танай -ны № -т

Зөвлөмжийн тухай

Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны зарцуулалтын нийцлийн аудитын тайлантай танилцлаа.

Тус тайланд тусгагдсан ОНХСангийн үйл ажиллагааны журмын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллах, түүний хэрэгжилтэд дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх ажлыг талаар холбогдох асуудлыг тодорхой шийдвэр гаргуулж байх зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллах болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.ДАВААДОРЖ

D:\My documents\ A-4.doc
J320202539


ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


**ОРХОН АЙМГИЙН
БАЯН-ӨНДӨР СУМЫН
ЗАСАГ ДАРГА**
61025 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Осуурт баг
Ш.Отгонбилэгийн гудамж
Утас: 70357965, Факс: 70350965
Цахим хаяг: www.bayandor.mn
Цахим шуудан: baodlg@gmail.com

2020.12.08 № 4/1293
танай _____-ны № _____-т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.НАРМАНДАХ ТАНАА**

Тус сумын 2019 оны ОНХС-ын зарцуулалтад хийгдсэн нийцлийн аудитын тайланд туслуулах саналгүй, өгөдсөн зөвлөмжийг цаашид бүрэн хэрэгжүүлж ажиллана.


ДАРГА  Б.БААСАНСҮРЭН

0000001294
D:/My Documents/ A-5. doc


**ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА**
61010 Орхон аймаг, Жаргалант сум, Жаргалант баг
Нутгийн удирдлагын ордон Утас: 70397203
Цахим хуудас: www.erdenet.mn

2020.12.08 № 01/823
танай _____-ны № _____-т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРМАНДАХ ТАНАА**

Тус сумын 2019 оны Орон нутгийн хөгжлийн санд хийсэн аудитын хяналт шалгалтын дүгнэлтэнд холбогдох саналгүй, өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллана.


ЗАСАГ ДАРГА  Е.ЗОРИГТБАЯР

000000760
D: Aulian denger A-5